



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/298

Ховд

Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр
орлуулан хаалгах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.4, 31.5, 31.5.1, 31.5.2, 31.6 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 85 дугаар тогтоол, 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 41 дүгээр “Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2020 онд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан иргэдийн нэрийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөс чөлөөлөгдсөн иргэдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар, 2021 онд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн нэрийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

2. Мөнгөн төлбөр төлөхөөр шийдвэрлэсэн цэргийн үүрэгтний тогтоосон мөнгийг цэргийн дүйцүүлэх алба, төрийн сангийн 100160000983 дансанд 2021 оны 12 дугаар сарын 20-ны дотор төлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга /хурандаа Б.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

3. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэлийг хөтлөх, төлбөрийн хэмжээ тогтоох, хураан авах, зохих дансанд байршуулах, зарцуулалтыг тайлагнах, мөнгөн төлбөрөө төлөөгүй цэргийн албанаас зайлсхийгчдийн асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх зэрэг ажиллагааг зохих хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж, иргэдэд хөнгөн шуурхай үйлчилж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга /хурандаа Б.Ганхуяг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02.1651
D/Zah-A/298-Bb